

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр № ХТ 01/2020

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 12.00 цагаас 16.40 цагын хооронд Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 7/2, Денвер оффис, 401 тоот, Эрдэнэс Сольюшинс ХХК-ийн байранд хуралдав.

Хурал зохион байгуулах комисс болон Тооллогын комиссоос хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцохоор ирсэн хувьцаа эзэмшигчдийн ирцийг бүртгэж, ирц 73.69/далан гурав зууны жаран ес/ хувь буюу 26'672/хорин зургаан мянга зургаан зуун далан хоёр/ ширхэг саналын эрхтэй хувьцааг эзэмшигчид оролцож байгаа талаар танилцуулав. Хэлэлцэх асуудал тус бүрээр “Санал асуултын хуудас”-ыг хувьцаа эзэмшигчдэд тараав. Түүнчлэн брокер дилерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс ямар нэгэн хуралтай холбоотой баримт, материал ирээгүй болохыг танилцуулав. Хурлын ирц компанийн дүрэм болон хуулийн дагуу бүрдсэн тул хурал хүчин төгөлдөр талаар шийдвэр гаргав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд Эрдэнэс сольюшинс ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ц.Хүдэрмөнх оролцож компанийн талаар танилцуулга хийв.

Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэрийн 2 дугаар хавсралтад заасан “Хурлын хөтөлбөр, дэг”-ийн дагуу хэлэлцэх асуудлын эхэнд хувьцаа эзэмшигчдээс хурлын даргыг сонгов.

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар 2020 оны 01-р сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын даргаар Б. Батхүүг сонгов.

Хурлыг нээж Б.Батхүү компанийн хөтөлбөрийн дагуу хэлэлцэх асуудлуудыг нэг бүрчлэн дэлгэрэнгүй уншиж танилцуулж, холбогдох шийдвэрүүдийн төслийг мөн дэлгэрэнгүй байдлаар уншиж танилцуулав.

Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэв. Үүнд:

1. Компанийн өнөөдрийн байдлаарх санхүүгийн болон үйл ажиллагааны байдал;
2. Эрдэнэс сольюшинс ХХК-иас ирүүлсэн Хар хорум пропертийс ХК-ны 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд Эрдэнэс сольюшинс ХХК-ийн 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг энгийн хувьцааг тэнцүүлж, Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл, Нэгтгэх гэрээний төслийг хэлэлцэж, батлах тухай;
3. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх талуудын 2019 оны 12-р сарын 31-ны байдлаар хөндлөнгийн аудит хийгдсэн санхүүгийн тайлан, хөрөнгийн үнэлгээний тайлан, хуулийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;
4. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан Хар хорум пропертийс ХК-ний зарласан энгийн хувьцаанаас хаалттай хүрээнд 1 ширхэг нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'751'262 /арван таван сая долоон зуун тавин

2020 ОНЫ 01-Р САРЫН 24-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА

/Б.БАТХҮҮ/



нэгэн мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг энгийн хувьцааг эргэлтэд нэмж эргэлтэд гаргах тухай;

5. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;
 6. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрх үүссэн тухай;
 7. Хар хорум пропертийс ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулах тухай;
 8. Хар хорум пропертийс ХК-ийн оршин байх хаягийг өөрчлөх тухай;
 9. Хар хорум пропертийс ХК-ийн оноосон нэрийг нэгтгэж буй Эрдэнэс сольюшинс ХХК-ийн оноосон нэрээр солих тухай;
 10. Хар хорум пропертийс ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай;
 11. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох тухай.
- Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу:

1-р хэлэлцэх асуудлаар:

1. Компанийн өнөөдрийн байдлаарх үйл ажиллагаа болон санхүүгийн байдлын талаар танилцуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- 1.1. Тус хувьцаат компани төлбөрийн чадваргүйн улмаас Монголын хөрөнгийн биржийн жил тутмын бүртгэлийн хураамжийг 2002 оноос хойш төлөөгүйгээс 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар 6'397'912 төгрөгт хүрсэн байна. Улмаар Монголын хөрөнгийн бирж хуримтлагдсан бүртгэлийн хураамжийг төлүүлэхээр Чингэлтэй дүүргийн шүүхэд өгсөн байна. Үүнд:

2002 – 2007 он-	240,000 төгрөг
2008 - 2011 он-	57,912 төгрөг
2012-2014 он –	3,600,000 төгрөг
2015-2018 он-	2,000,000 төгрөг
2019 он-	500,000 төгрөг
Нийт	6,397,912 төгрөг байна.

Компани “Үнэт цаасны төвлөрсөн хадгалмжийн төв”-д хувьцаагаа хадгалуулсаны үйлчилгээний хуримтлагдсан төлбөр дараах байдалтай байна. Үүнд:


2012 он-	60,000 төгрөг	2016 он-	60,000 төгрөг
2013 он -	60,000 төгрөг	2017 он-	100,000 төгрөг
2014 он-	60,000 төгрөг	2018 он-	100,000 төгрөг
2015 он-	60,000 төгрөг	2019 он-	100,000 төгрөг
Нийт			600,000 төгрөг тус тус байна.

Тус компанийн өөрийн хөрөнгө 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар **хасах** 10'759'585.40 төгрөгт хүрч, өр нь 10'804'885.40 төгрөгт тус тус хүрсэн байна.

Энэ нь Компанийн тухай хуулийн 61.1.3-т заасан компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн, 61.1.4-т заасан компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөнөөс илүү болж, хасах утгатай болсон тохиолдолд хуулийн 61 дүгээр зүйлийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах нөхцөл үүсгээд байна.

- 1.2. Энэ хувьцаат компани маань ямар нэгэн актив хөрөнгө байхгүй, хувьцаа нь Монголын 2020 ОНЫ 01-Р САРЫН 24-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРАА

Б.БАТХҮҮ/



хөрөнгийн бирж дээр арилжигддаг хоосон компанийг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. Компани нь нэг бүрийн 100\нэг зуу\төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 36'195\гучин зургаан мянга нэг зуун ерэн тав\ширхэг гаргасан энгийн хувьцаатай байх бөгөөд Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу компани нь нийт 3'619'500\гурван сая зургаан зуун арван есөн мянга таван зуу\ төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй хамгийн сүүлд 2013 оны 06-р сарын 07 өдөр 1 ширхэг хувьцаа 78 төгрөгөөр нэрлэсэн үнээсээ доогуур арилжигдаж, өнөөдрийн байдлаар ердөө 2,823,210 төгрөгийн үнэлгээтэй компани болсон байна. Түүнээс хойш өнөөдрийг хүртэл нэг ч хувьцааны арилжаа хийгдээгүй, идэвхгүй байна.

1.3.Компанийн оноосон нэрийг сольж сүүлийн 5 жилийн турш өөрчлөлт хийж, үйл ажиллагаагаа идэвхжүүлэх гэж оролдсон боловч Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн хүндрэл, хөрөнгө оруулагчдын сонирхол байхгүй зэргээс болж компани ямар нэгэн үйл ажиллагаа явуулж чадсангүй. Түүнчлэн Гүйцэтгэх захирал Д. Энхбаатар нь энэ хугацаанд одоо болтол олдохгүй байгаа бөгөөд ямар нэгэн байдлаар холбогдож чадаагүй болно.

1.4.Тус компанид Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 01-р сарын 27-ны өдрийн 9/249 албан тоот бичгээр ирүүлсэн “Хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөгөө хүргүүлэх тухай”, 2017 оны 01-р сарын 20-ны өдрийн 9/210 тоот “Даалгавар өгөх тухай” албан бичгээр ирүүлсэн бичгүүдэд компанийг удаа дараа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль баримтлан ажиллах, компанийн үнэлгээ хийлгэх тухай шаардлагуудыг удаа дараа ирүүлсэн байна.

1.5.Тус хувьцаат компани цаашдын үйл ажиллагаа ийм хэвээр үргэлжилбэл санхүүгийн байдал эрс муудаж, төлбөрийн чадваргүй болж Шүүхийн шийдвэрээр үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоож, дампуурах эрсдэлтэй болсон байна гэж үзэж байна. Ийм тохиолдолд компанийн хувьцаа эзэмшигч 130 гаруй иргэн, хуулийн этгээд бүрэн хохирох эрсдэлтэй байна.

2-р хэлэлцэх асуудлаар:

Эдгээр хэлэлцэх асуудлуудыг дэс дараалалын дагуу танилцуулья:

Эрдэнэс сольюшинс ХХК-иас

- Эрдэнэс сольюшинс ХХК-ны танилцуулга;
- 2019 оны 12-р сарын 31-ний санхүүгийн тайлан;
- компанийн гэрчилгээний болон дүрмийн хуулбар;
- тус компанид нэгдэж орох тухай санал;
- Хар хорум пропертийс ХХК-ны 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд Эрдэнэс сольюшинс ХХК-ийн 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг энгийн хувьцааг тэнцүүлж, Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл; Нэгтгэх гэрээний төсөл;
- Эрдэнэс сольюшинс ХХК Компанийн нэгтгэл хийх Хөрөнгийн үнэлгээний компани, Хөндлөнгийн аудитын компани, Хуулийн дүнэлт гаргах компани, нэгтгэн нийлүүлэх андеррайтерын компанитай гэрээ байгуулж, гарах зардлыг өөрсдийнхөө хөрөнгөөр бүрэн хариуцах тухай;
- Хар хорум пропертийс ХХК-ийн Монголын хөрөнгийн биржид төлөх хуримтлагдсан жил тутмын бүртгэлийн хураамжийг болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх үнэт цаас хадгалуулсаны үйлчилгээний төлбөрийг өөрсдийнхөө хөрөнгөөр төлж барагдуулах тухай албан бичгийг ирүүлсэн.

Та бүхэн уншиж танилцсан байхаа. Энэ компани нь програм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Нийт энгийн хувьцааны 70 гаруй хувийг буюу хамгийн том хувьцаа эзэмшигч нь толгой компани болох Субашид тек ХХК нь байна. Толгой компани болох Субашид тек ХХК нь 4 хувьцаа эзэмшигчтэй тус бүр 25%-ийг хуваан эзэмшдэг. Толгой компани нь програм хангамжаа хийдэг, бүтээгдхүүний борлуулалтаа охин компани болох нэгдэх гээд байгаа Эрдэнэс сольюшинс ХХК нь хийдэг.

2020 ОНЫ 01-Р САРЫН 24-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРГА



Толгой компани нь үнэт арин банк, брокерийн компаниудтай хамтраад Үнэт цаасны төлбөр тооцооны болон алсын зайнаас брокерын компанид болон арилжааны банкинд дансаа нээх систем нэвтрүүлсэн компани болно. Дэлгэрэнгүйг компанийн таницуулганаас харсан байх. Эрдэнэс сольюшинс компаниас 2019 оны 11-р сарын 20-ны өдрийн 18/2019 тоот албан бичгээр Хар хорум пропертийс ХК-д нэгдэж орох санал тавьсан билээ. Түүнчлэн 2020 оны 01-р сарын 20-ны өдрийн 20/2020 тоот албан бичгээр Хар хорумын ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдэд Эрдэнэс сольюшинс ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл болон “Нэгдэж ороход эзэмшүүлэх энгийн хувьцааны тоо ширхэгийн санал” тавьсан. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хөрөнгийн үнэлгээний Мөнх-Оргил трэйд ХХК-иар Эрдэнэс сольюшинс ХХК-ийн 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар хөрөнгийн үнэлгээг 1,579.0 (нэг тэрбум таван зуун далан есөн сая) төгрөгөөр үнэлсэнийг;
2. Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй Пи Кэй Эф Монголиа (Координат аудит) ХХК-иар Эрдэнэс сольюшинс ХХК-ийн санхүүгийн тайланд 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар хөндлөнгийн аудит хийлгэсэнийг;
3. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахад нэгдэж орох Эрдэнэс сольюшинс ХХК-ийн 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн эцсийн байдлаарх хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувьцаа эзэмшлийн хэмжээг компанийн дүрэмд туссаныг;
4. Тус компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө 2019 оны 12-р сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 1'575'126'230 /нэг тэрбум таван зуун далан таван сая нэг зуун хорин зургаан мянга хоёр зуун гуч/ ширхэг буюу 1'575'126'230 /нэг тэрбум таван зуун далан таван сая нэг зуун хорин зургаан мянга хоёр зуун гуч/ төгрөгийн үнэ бүхий энгийн хувьцаатайг;
5. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01-р сарын 19-ны өдрийн хурлаас хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр нэгдэж орохоор шийдвэрлэсэнийг;
6. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01-р сарын 15-ны өдрийн хурлаас хувьцаа эзэмшигчид 100 % санал нэгтгэйгээр Хар хорум пропертийс ХК-ийн 1 ширхэг нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй энгийн хувьцаанд Эрдэнэс сольюшинс ХХК-ийн 1 ширхэг нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг хувьцаанд хөрвүүлж нэгдэж орохоор шийдвэрлэсэнийг;
7. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01-р сарын 15-ны өдрийн хурлаас хувьцаа эзэмшигчид 100% санал нэгтгэйгээр Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг “Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл” болон “Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх гэрээ”-г батлаж шийдвэрлэсэн болохийг;
8. Нэгдэж орох Эрдэнэс сольюшинс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж Хар хорум пропертийс ХК-ийн 2020 оны 01-р сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлаас 1 бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'751'262 /арван таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд эргэлтэд нэмж гаргаж эзэмшүүлэхийг албан бичгээр санал болгосон байна. Холбогдох хурлын шийдвэр хөрөнгийн болон үнэлгээний тайланг ирүүлсэн байна.

Компанийг яагаад нэгтгэх болсон тухай дээр дэлгэрэнгүй танилцуулсан. Яагаад энэ компани вэ гэхээр энэ компани чинь ирээдүйтэй програм хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани, мэдлэг туршлагатай залуучууд ажилуулж байна, компанийн үйл ажиллагаа болон

2020 ОНЫ 01-Р САРЫН 24-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА /Б.БАТХҮҮ/



санхүүгийн байдал ирээдүйтэй чадамжтай байна, хувьцаа эзэмшигчид нь нэгтгэхийг зөвшөөрч байна.

Нэгтгэсний дараа хувьцаа эзэмшигчдийн Хар хорум пропертийс ХК-д эзлэх хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшил 1%-иас доош орох болохыг давхар анхаарана уу. Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөлд тодорхой туссан байгаа шүү.

Үүнийг хувьцаа эзэмшигчид маань шийдэх байх. Хувьцаат компани маань актив хөрөнгөгүй тул хөрөнгийн үнэлгээ -10,8 сая төгрөг гарсан байна. Толгой компани нь өөрийн хийсэн, оюуны өмч бүхий актив хөрөнгийг 2019 оны 08-р сарын 05-ны өдрийн байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлтэй хөрөнгийн үнэлгээний Мөнх оргил трейд ХХК-иар хийлгэж, Эрдэнэс сольюшинс ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн юм байна.

“Нэгтгэх Компанийн танилцуулга”, Санхүүгийн үйл ажиллагааны 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар тайлан болон “Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл”, “Нэгтгэх гэрээ”-ний төслүүдийг та бүхэнд бичгээр танилцуулж байна. Иймд та бүхэн энэ асуудалд ултай суурьтай хандана уу. Эрдэнэс сольюшинс ХХК-иас Хар хорум пропертийс ХК-ны 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд Эрдэнэс сольюшинс ХХК-ийн 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг энгийн хувьцааг тэнцүүлж, Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл гаргаж нэгтгэх санал тавьсан. Энэ замаар нэгдэж ороход Хар хорум пропертийс ХК-ны хувьцаа эзэмшигчдийн хувь эзэмшлийн хэмжээ дараах байдлаар өөрчлөгдөхөөр байна.

Энийг хувьцааны бутархай 0.3 хувийг Компанийн тухай хуулийн 51.4-т заасны дагуу компани худалдаж авах нээ.

Томоохон хувьцаа эзэмшигчид	Нэгдэхийн өмнөх хувь		Нэгдсэний дараах хувь эзэмшил	
	Эзэмшлийн нийт ширхэг	эзэмшлийн хувь	Эзэмшлийн нийт ширхэг	эзэмшлийн хувь
Экспонэйншл фонд менежмент ҮЦК	15,097	41.7%	15,097	0.10%
Б.Баярмаа	11,570	32.0%	11,570	0.07%
Бусад хувьцаа эзэмшигчид	9,528	26.3%	9,528	0.06%
Нийт	36,195	100.0%	36,195	0.23%
Эрдэнэс сольюшинс ХХК-ийн хувьцаа эзэмшил			15,751,262	99.77%
Үүнээс:				
Субашид тек ХХК			11,241,262	71.20%
М. Бат-Эрдэнэ			940,000	5.95%
Ц. Хүдэрмөнх			940,000	5.95%
Г. Дулмаа			940,000	5.95%
Т. Дөлгөөн			940,000	5.95%
Э. Цэндсүрэн			450,000	2.85%
Г. Аззаяа			150,000	0.95%
Ц. Хишигбаатарт			150,000	0.95%
Нэгдсэний дараах хувьцааны нийт тоо ширхэг, хувь			15,787,457	100.00%

Энэ асуудлыг Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороо хэлэлцэн шийдвэрлэж байж нэгтгэгдэнэ.


3-р хэлэлцэх асуудлаар:

Нэгтгэх болон нэгтгэгдэх компанийн санхүүгийн тайлан, хөрөнгийн үнэлгээний тайлан, хуулийн дүгнэлт 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар гарсан байна.

4,5,6 -р хэлэлцэх асуудлаар:

Хэрэв хувьцаа эзэмшигчид Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг дээрх 1 ширхэг хувьцаанд ноогдох саналыг хүлээн авч нэгтгэхээр шийдвэрлэвэл Хар хорум пропертийс

2020 ОНЫ 01-Р САРЫН 24-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРГА



/Б.БАТХҮҮ/

ХК-ийн зарласан энгийн хувьцаанаас 1 бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'751'262 /арван таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг энгийн хувьцааг эргэлтэд нэмж гаргана.

Тус компани нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарахгүй нэг бүрийн 100\нэг зуу\төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 2'000'000'000\хоёр тэрбум\ширхэг зарласан энгийн хувьцаатай. Хэрэв Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэвэл хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд хувьцаа эзэмшигчид худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх саналтай байна. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэвэл мэдээж компанийн тухай хуулиар хувьцаа эзэмшигчдийн хуралд эсрэг саналтай байсан, хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн хохиролгүй байх үүднээс хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрх үүсэх байх. Хар хорум пропертийс ХК-ийн үйл ажиллагааны чиглэл нь хоёр компанийн үйл ажиллагааны чиглэл байхаас гадна нэмж худалдааны зуучлал хийх чиглэл нэмэх саналтай байгаа юм байна. Үүнийг Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэсэн байна үүнийгээ хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж байна.

7,8,9,10-р хэлэлцэх асуудлаар:

Хар хорум пропертийс ХК-ний оршин буй хаяг нь нэгтгэж орж байгаа Эрдэнэс сольюшинс ХХК-ийн хаягаар солигдоно. Энэ хаяг нь УБ хот, ЧД, 1-р хороо, Энх тайваны өргөн чөлөө, 7/2, Денвер оффис, 401 тоот болох байх.

Хар хорум пропертийс ХК-ийн оноосон нэрийг нэгтгэж буй Эрдэнэс сольюшинс ХХК-ийн оноосон нэрээр солих хүсэлтэй байгаа Эрдэнэс сольюшинс ХХК-иас хүссэн. Учир нь пропертийс гэдэг нэр нь дан үндсэн хөрөнгийн чиглэлээр байгаа учир илүү өргөн үйл ажиллагаа явуулах гэдэг утгаар нь нэр солилуулах хүсэлт гаргасан. Энэ асуудлыг шийдвэрлүүлье. Тэгэхдээ энэ хурлаар шийдвэрлүүсэнээс хойш 30 хоногийн хугацаанд нэр солигдох болов уу.

Дээрх бүх хэлэлцэх асуудлыг шийдвэрлэсний дараа Хар хорум пропертийс ХК-ийн Дүрмийг батлах байх. Урьдчилан, дээрх асуудлуудыг тусгасан Дүрмийн төсөл нь энэ байна.

Хэрэв компанийг нэгтгэвэл Хар хорум пропертийс ХК-ийн Монголын хөрөнгийн биржид төлөх хуримтлагдсан жил бүрийн бүртгэлийн хураамж болон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд үнэт цаасаа хадгалуулсаны үйлчилгээний хуримтлагдсан төлбөр болох нийт бараг 7 сая төгрөгийг Эрдэнэс сольюшинс ХХК төлье гэсэн байна. Үүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал дээрээ мэдэгдэж байна. Хөрөнгийн үнэлгээний компани, Хөндлөнгийн аудитын компани, Хуулийн дүнэлт гаргах компани, нэгтгэн нийлүүлэх андеррайтерын компанитай гэрээ байгуулах бүх зардлыг Эрдэнэс сольюшинс ХХК хариуцаж байгаа. Энэ нийт зардал 50-100 сая төгрөгийн хооронд байх болов уу.

Компанийг нэгтгэсний дараа шинэ хувьцаа эзэмшигчид өөрсдийн төлөөлөл болгож, ТУЗ-ын гишүүдийг нэр дэвшүүлж байгаа юм байна. Нөгөө талаас компанийн дүрмээр ТУЗ-ын гишүүд 1 жилийн хугацаатай байдаг. Нэр дэвшүүлж буй хүмүүсийн танилцуулга нь энэ байна. Компанийн үйл ажиллагааг тогтвортой явуулах зорилгоор 3 жил болгон өөрчлөх саналтай байна.

Хувьцаа эзэмшигч Б.Баярмаа: Миний бие ТУЗ-ын хурал дээр ярьсан зүйлээ давтаад ярья. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн танилцуулга, ирүүлсэн албан бичиг, Нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл болон гэрээтэй танилцлаа Энэ компани чинь програм хангамж, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах юм байна. Тийм үү? Нэгэнт хувьцаа эзэмшигчээс Компанийн тухай хуульд заасаны дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралдуулах санал гаргаж, хэлэлцүүлэх асуудлуудыг оруулж иржээ. Би ч гэсэн энэ компанид 32 хувийг эзэмшдэг. Нэгтгэвэл миний хувь багасах нээ.

Хэдийгээр миний хувь буурсан ч хувьцаа маань биежиж байна. Компанийн цаашдын ирээдүйн асуудал учираас Компанийг нэгтгэх саналыг хүлээн авч, дэмжиж байна. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоонд тохируулсан Хар хорум пропертийс ХК-ийн

2020 ОНЫ 01-Р САРЫН 24-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА



зарласан энгийн хувьцаанаас 1 бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'751'262 /арван таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг энгийн хувьцааг эргэлтэд нэмж гаргая.Нэгтгэх Гэрээнд гарын үсэг зурах эрхийг хувьцаа эзэмшигч Б. Батхүүд өгье.

Компани нэгтгэх асуудлаар Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1, 88.2, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2, 91 дүгээр зүйлийн 91.2, 92 дугаар зүйлийн 92.1, 92.3, 92.4 дах заалт, Компанийн дүрмийн 20.1, 21.1 заасаны дагуу миний хамаарал бүхий этгээд болох ээж маань Нэгтгэгдэж буй компанид хувь эзэмшиж бие сонирхолын зөрчилтэй тул хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралын санал хураалтад орох боломжгүй байна. Иймд сонирхолын зөрчилгүй хувьцаа эзэмшигч санал хураалтад оролцоно.

“Хар хорум пропертийс” ХК-ийн 2019 оны 12-р сарын 31-ний байдлаарх аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг, хөрөнгийн үнэлгээний тайлан, хуулийн дүгнэлтийг танилцуулав. Холбогдох хурлын шийдвэрийн төслийг уншиж танилцуулав.

Хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэж байгаа асуудлууд болон хурлын шийдвэрийн төслүүдэд ямар нэгэн санал өгөх, асууж тодруулах зүйл байгаа эсэхийг тодруулахад ямар нэгэн санал тодруулах зүйл гарсангүй.

Тооллогын комисс хувьцаа эзэмшигчдээс бөглөсөн саналын хуудсыг цуглуулан санал хураалтын дүнг нэгтгэв.

Тооллогын комиссоос санал хураалтын дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд хэлэлцсэн асуудал тус бүрээр танилцуулж, санал өгсөн нийт тоо ширхэг, эсрэг саналтай болон түдгэлзсэн саналын талаар дэлгэрэнгүй танилцуулав. Үүнд: Хүчингүй болсон саналын хуудас, татгалзсан болон түдгэлзсэн саналын хуудас гараагүй. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хувьцаа эзэмшигчид хэлэлцсэн асуудал бүрийг дэмжиж хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100/нэг зуу/ хувийн саналаар ЗӨВШӨӨРСӨН санал өгсөн компани нэгтгэх болсоныг танилцуулав.

Хурлын тооллогын комиссоос “Тооллогын комиссын тогтоол”-уудыг нэг бүрчлэн уншиж танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэр бүрийг хурлын дарга нэг бүрчлэн уншиж танилцуулав.

Хурлын дарга “Хар хорум пропертийс” ХК-ны ээлжит бус хурал үр дүнтэй, амжилттай болсоныг тэмдэглээд хурал хаасныг мэдэгдэв.

2020 ОНЫ 01-Р САРЫН 24-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН ДАРГА



“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААС ДАРААХ АСУУДЛУУДЫГ ШИЙДВЭРЛЭВ. ҮҮНД:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Б.Батхүүг сонгов.
2. Эрдэнэс сольюшинс ХХК-иас ирүүлсэн Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХК-ийг “Хар хорум пропертийс” ХК-ийн нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 (нэг) ширхэг энгийн хувьцаанд “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн нэг бүр нь 1 (нэг) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 (нэг зуу) ширхэг энгийн хувьцаатай хувь тэнцүүлэн хөрвүүлж, нэгтгэхээр шийдвэрлэв;
3. “Хар хорум пропертийс ХК-нд ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл” болон “Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх гэрээ”-г дэмжин батлаж, тус компанид Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхээр компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.1, 88.2, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2, 91 дүгээр зүйлийн 91.2, 92 дугаар зүйлийн 92.1, 92.3, 92.4 дах заалт, Компанийн дүрмийн 20.1, 21.1 сонирхолын зөрчилгүй хувьцаа эзэмшигчийн 100% саналаар, их хэмжээний болон сонирхолын зөрчилтэй хэлцэл байгуулав;
4. Тус компанийн 2019 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн тайланд “Пи Кэй Эф Монголиа Аудит” ХХК-ийн хийсэн хөндлөнгийн аудит тайлан, “Мөнх-Оргил трэйд” ХХК-ийн хийсэн хөрөнгийн үнэлгээний тайланг тус тус батлаж, нэгтгэх гэж буй Эрдэнэс сольюшинс ХХК-иас ирүүлсэн Эрдэнэс сольюшинс ХХК-ийн 2019 оны 12-р сарын 31-нээрх хөндлөнгийн аудит хийгдсэн санхүүгийн тайлан, хөрөнгийн үнэлгээний тайланг зөвшөөрөв;
5. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан Хар хорум пропертийс ХК-ний зарласан энгийн хувьцаанаас хаалттай хүрээнд 1 ширхэг нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'751'262 /арван таван сая долоон зуун тавин нэгэн мянга хоёр зуун жаран хоёр/ ширхэг энгийн хувьцааг эргэлтэд нэмж гаргав;
6. Нэгтгэх үед үүсэж буй бутархай 0.3 /тэг аравны гурав/ ширхэг хувьцааг компани халаасны хувьцаа болгон худалдан авав;
7. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байхаар шийдвэрлэв;
8. Хар хорум пропертийс ХК-д Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрх үүссэн тухай мэдэгдэж худалдаж авах үнэ тогтоох, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг ТУЗ-д даалгав;
9. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх гэрээнд “Хар хорум пропертийс” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг энэхүү Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдах өдрийн байдлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж буй хувьцаа эзэмшигч иргэн Б.Батхүүд олгов;
10. Хар хорум пропертийс ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд гадаад худалдаа; программ хангамжийн үйл ажиллагаа; программ хангамж, компьютерын тоног төхөөрөмжийн худалдаа; вэб сайт хийх; вэб сайтаар онлайн худалдаа эрхлэх; мэдээллийн технологи; худалдааны зуучлал үйл ажиллагааны чиглэлийг нэмэв;
11. Хар хорум пропертийс ХК-ийн оршин байх хаягийг Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 7/2, Денвер оффис, 401 тоот, Эрдэнэс Сольюшинс ХХК-ийн өөрчлөв;
12. Хар хорум пропертийс ХК-ийн оноосон нэрийг нэгтгэж буй Эрдэнэс сольюшинс ХХК-ийн оноосон нэрээр солив;
13. Хар хорум пропертийс ХК-ийн Дүрмийг батлав;
14. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилов.
15. Тус компанийн шүүхийн нэхэмжлэл бүхий Монголын хөрөнгийн биржид төлөх жил тутмын хуримтлагдсан бүртгэлийн хураамжийг төлөх асуудлыг Монголын хөрөнгийн биржтэй Эвлэрэлийн гэрээ байгуулах замаар тохиролцож, Компанийн өмнөөс төлөхийг Эрдэнэс сольюшинс ХХК-д зөвшөөрөв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ



2020 ОНЫ 01-Р САРЫН 24-НИЙ ӨДРИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДАРГА

Ж.БАЯРМАА/
/ЭКСПОНЭЙНЦЛ ФАНД
МЕНЕЖМЕНТ ҮЦК ХХК/
Б.БАТХҮҮ/

